
**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ СОЁЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ**

СҮХБААТАРЫН ГАНЗАЯА

**Монгол улсад бүртгэгдсэн сүрьеэ өвчний тархвар зүйд байгаль
цаг уур, нийгмийн зарим хүчин зүйлсийн нөлөө**

E-720001

**Анагаах Ухааны магистрын зэрэг горилсон
нэг сэдэвт бүтээл**

**Улаанбаатар хот
2008 он**

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ СОЁЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ**

СҮХБААТАРЫН ГАНЗАЯА

**Монгол улсад бүртгэгдсэн сүрьеэ өвчний тархвар зүйд байгаль
цаг уур, нийгмийн зарим хүчин зүйлсийн нөлөө**

E-720001

**Анагаах Ухааны магистрын зэрэг горилсон
нэг сэдэвт бүтээл**

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч :

Анагаах Ухааны доктор Н.Наранбат

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

Анагаах Ухааны доктор, дэд профессор О.Чимэдсүрэн

**Улаанбаатар хот
2008 он**

АГУУЛГА

Нэгдүгээр бүлэг. Удиртгал

1.1 Асуудал чухал болох нь	4
1.2 Судалгааны зорилго, зорилт.....	5-6
1.3 Судалгааны таамаглал.....	6
1.4 Шинжлэх ухааны шинэлэг тал.....	6
1.5 Судалгааны ажлын практик ач холбогдол.....	6
1.6 Хамгаалахаар дэвшүүлж байгаа гол асуудлууд.....	6
1.7 Судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлсэн байдал.....	7
1.8 Судалгааны ажлын бүтэц хүрээ.....	7

Хоёрдугаар бүлэг. Сэдвийн судлагдсан байдал өнөөгийн түвшин

2.1 Сүрьеэгийн өвчлөлийн дэлхий дахины хандлага.....	8-13
2.2 Монгол улс дахь сүрьеэ өвчний хандлага.....	13-17

Гуравдугаар бүлэг. Судалгааны арга ба материал

3.1 Судалгааны загвар.....	18
3.2 Судалгааны хүрээ.....	18
3.3 Судалгааны аргачлал.....	18-19
3.4 Судалгааны боловсруулалт.....	19

Дөрөвдүгээр бүлэг. Судалгааны үр дүн

4.1 Монгол улсад бүртгэгдсэн сүрьеэгийн тархалтын өнгөрсөн, одоо, ирээдүйн төлөв байдал, хандлага.....	20-36
4.2 Сүрьеэ өвчний тархалтанд манай орны байгаль цаг уурын зарим хүчин зүйлийн хамаарал, улиралчлалыг судалсан дүн.....	36-47
4.3 Улаанбаатар хотод бүртгэгдсэн уушигны халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний онцлого.....	47-53

Тавдугаар бүлэг. Судалгааны үр дүнгийн хэлцэмж

5.1 Монгол улсад бүртгэгдсэн сүрьеэ өвчний эпидемиологийн зарим үзүүлэлтэд дүн шинжилгээ хийсэн дүн.....	54-55
5.2 Сүрьеэ өвчинд нөлөөлөх байгаль цаг уурын зарим нөлөөг судалсан дүн	55-58
5.3 Сүрьеэгийн өвчлөлд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг судалсан дүн.....	58-59

Судалгааны ажлын дүгнэлт	60
--------------------------------	----

Практик зөвлөмж	61
-----------------------	----

Судалгааны сэдвээр хэвлэгдсэн бүтээл.....	62
---	----

Ном зүй.....	63-66
--------------	-------


Удиртгал

1.1. Асуудал чухал болох нь:

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-ын экспертүүдийн тооцоолсноор дэлхийн нийт хүн амын гуравны нэг буюу 1.7 тэрбум хүн одоо сүрьеэгийн халдвар авч жил бүр 8 сая хүн шинээр өвчилж 2 сая орчим нь нас барж, сүрьеэтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэхгүй бол ирэх 10 жилд 100 сая хүн нэмж халдвар аван, 20 сая хүн сүрьеэгээр нас барах тооцоо байна. Иймээс ДЭМБ 1993 онд сүрьеэтэй тэмцэх бодлого шинээр боловсруулж 2010 он гэхэд сүрьеэгийн өвчлөлийг одоо байгаа түвшингээс 2 дахин бууруулах зорилго тавьж гишүүн орнууддаа Сүрьеэтэй Тэмцэх Үндэсний Хөтөлбөр (СТҮХ) хэрэгжүүлэхийг уриалсан билээ [54,55]. ДЭМБ-ын стратеги нь халдвартай хэлбэрийн сүрьеэг эрт илрүүлэн, стандартжуулсан богино-хугацааны бүрдмэл хими-заслаар төгс эмчилж, халдвар дамжих гинжин хэлхээг таслан зогсоосноор сүрьеэг бууруулах явдал юм. Иймд Шууд Хяналттай Богино-Хугацааны Эмчилгээ (ШХБХЭ)-ний цогц бодлого хэрэгжүүлж ирлээ. Энэ бодлогын үндсэн 2 зорилт нь сүрьеэгийн халдвартай тохиолдлын 70-аас доошгүй хувийг илрүүлж, шинэ бүртгэгдсэн халдвартай хэлбэрийн сүрьеэгийн 85-аас доошгүй хувийг бүрэн төгс эмчлэхэд чиглэгдэж байна [4, 20].

Монгол улсын Засгийн Газар 1994 онд шинэ СТҮХ-ийг ШХБЭ-ний бодлогод тулгуурлан өөрийн орны нөхцөлд зохицуулан боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлснээр сүрьеэтэй тэмцэх ажилд мэдэгдэхүйц ахиц гарч 1993 онд сүрьеэгийн нийт бүртгэгдсэн тохиолдлын дотор халдвартай хэлбэрийн сүрьеэгийн эзлэх хувь 6.2, шинэ бүртгэгдсэн халдвартай хэлбэрийн сүрьеэгийн эдгэрэлтийн түвшин 31.4% байсан нь 2006 онд халдвартай хэлбэрийн сүрьеэгийн эзлэх хувь 76.8, эдгэрэлтийн түвшин 82.1 хувьд хүрч 340 гаруй мянган хүн шинээр сүрьеэгийн халдварт өртөх, 30 гаруй мянган хүнийг сүрьеэгээр өвчлөхөөс сэргийлж чадлаа [5, 33].

Гэвч манай улсын сүрьеэгийн өвчлөл дорвитой буурахгүй байгаа бөгөөд 1994 онд 100 000 хүн амд сүрьеэгийн 76 шинэ тохиолдол бүртгэгдэж байсан бол 1995 онд 116, 1996 онд 141, 1997 онд 120, 1998 онд 117, 1999 онд 133, 2000 онд 125, 2001 онд 141, 2002 онд 152, 2003 онд 153, 2004 онд 177, 2005 онд 173, 2006 онд 185 болж, сүүлийн 12 жилд сүрьеэгийн шинээр бүртгэгдсэн өвчлөл 2.4 дахин нэмэгджээ [33](Зураг 1).



Зураг 1. Монгол улсад бүртгэгдсэн сүрьеэгийн өвчлөл 1994-2006 он

Ер нь 1980-аад оны сүүлч 1990-ээд оны эхээр дархлалын олдмол хомсдол (ДОХ) өвчинтэй хоршоод сүрьеэ өвчин дэлхий дахинд дахин цар тахал хэлбэрт шилжиж, сүрьеэгийн өвчлөл хөгжиж байгаа орнуудад төдийгүй, аж үйлдвэржсэн орнуудад ч эрс нэмэгдэж байна. Сүрьеэгийн өвчлөл нэмэгдэж байгаа нь нэг талаас ШХБЭ-ний бодлогыг улс орнууд шат дараатай амжилттай хэрэгжүүлснээр сүрьеэгийн илрүүлэлт сайжирсан, нөгөө талаас аялал жуулчлал нэмэгдэн зах хязгаараас хот сууринд шилжих шилжилт хөдөлгөөн, ажилгүйдэл, ядуурал ихэссэн, амьжиргааны түвшин нийгмийн үйлчилгээний чанар муудсан гэх мэт нийгмийн эрсдэлт хүчин зүйл нэмэгдсэнтэй холбоотой [12].

Сүрьеэтэй тэмцэх ажил нь сүрьеэ өвчний тархвар зүйн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг судлахгүйгээр амжилтанд хүрэхгүй байна. Харамсалтай нь Монгол улсад энэ талын судалгаа нэн хоцрогдонгуй байгаа нь сүрьеэтэй амжилттай тэмцэхэд бэрхшээл учруулж буй тул сүрьеэ өвчний тархвар судлалын байдал түүнд нөлөөлөх байгаль цаг уур, нийгмийн зарим хүчин зүйлсийг судлан тогтоох нь манай эрүүлийг хамгаалахын тулгамдсан асуудал болж байна.

1.2 Судалгааны зорилго ба зорилт:

Монгол улсын хүн амын дунд бүртгэгдсэн сүрьеэ өвчний тархвар судлалд байгаль цаг уур, нийгмийн зарим хүчин зүйлсийн хамаарлыг судлахад оршино. Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахи зорилтуудыг дэвшүүлэн тавилаа. Үүнд :

-
1. Сүрьеэ өвчний тархалтын өнгөрсөн одоо ирээдүйн төлөв байдал, хандлагыг 2010 он хүртэл тодорхойлох
 2. Сүрьеэ өвчний тархалтанд манай орны байгаль цаг уурын зарим хүчин зүйлийн хамаарлыг тогтоох
 3. Улаанбаатар хотод бүртгэгдсэн уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэгийн өвчлөлд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг тогтоох

1.3 Судалгааны таамаглал

Сүрьеэгийн тархалт манай улсад харилцан адилгүй тархалттай ба сүрьеэгийн өвчлөл ирэх 2010 он хүртэл тасралтгүй ихсэх хандлагтай байна. Манай улсад уушигны сүрьеэ хавар, зуны улиралд ихсэж, өвлийн улиралд буурдаг зүй тогтол ажиглагдаж байна. Аймагуудын далайн түвшнээс дээш өргөгдсөн түвшин уушигны түрхэц эерэг сүрьеэгийн өвчлөлд урвуу, хүн амын нягтралтай шууд хамааралтай байна. Сүрьеэ өвчин нь нийгмийн ядуу, эмзэг хэсгийн дотор өргөн тархсан эмгэг гэдэг нь ажиглагдаж байна.

1.4 Шинжлэх ухааны шинэлэг тал

Энэхүү судалгааг хийсэнээрээ сүрьеэ өвчний тархалтанд байгаль болоод нийгмийн талаас нөлөөлж болох хэд хэдэн хүчин зүйлсийг судлан таамагласнаар цаашид нарийвчлан судлах асуудлыг тодорхойлход чухал алхам боллоо.

1.5 Судалгааны ажлын практик ач холбогдол

Монгол улсад бүртгэгдэж буй сүрьеэ өвчний тархвар судлалд нөлөөлөх зарим хүчин зүйлүүдийг судлан тогтоосноор сүрьеэ өвчнийг хянах үйл ажиллагааг оновчтой төлөвлөн, зохион байгуулах боломжийг дээшлүүлнэ.

1.6 Хамгаалахаар дэвшүүлж байгаа гол асуудлууд

1. Хүн амын дунд гарч буй сүрьеэгийн өвчлөлд тархвар судлалын дүгнэлт өгөх, цаашдын хандлагыг судалсан дүн
2. Сүрьеэ өвчинд нөлөөлөх байгаль цаг уурын зарим нөлөөллийг судалсан дүн
3. Халдвартай хэлбэрийн сүрьеэгийн өвчлөлд нөлөөлөх нийгмийн зарим эрсдэлт хүчин зүйлсийг судалсан дүн

1.7. Судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлсэн байдал

1. Сүрьеэгийн үндэсний V семинар
2. "Монголын анагаах ухааны уламжлал, шинэчлэлийн асуудалд" эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн.

Судалгааны үр дүнгээр 2 илтгэлийн хураангуй, 3 өгүүлэл дотоодын мэргэжлийн сэтгүүлд болон хурлын материалд хэвлүүлсэн.

1.8. Судалгааны ажлын бүтэц, хүрээ

Судалгааны ажил нь монгол хэл дээр бичигдсэн 68 хуудастай бөгөөд хүснэгт 17, зураг 61-ыг багтаасан болно. Энэхүү судалгааны ажил нь удиртгал, сэдвийн судлагдсан байдал, судалгааны арга ба материал, судалгааны үр дүн, судалгааны үр дүнгийн хэлцэмж, дүгнэлт, практик зөвлөмж, ном зүй гэсэн хэсгүүдээс тогтоно.

Монгол хэлээр

1. Ганзаяа.С, Наряд.С, Дондог.Н, 2005: Монгол улс дахь сүрьеэ өвчний тархвар судлалын зарим асуудал, “Халдварт Өвчин Судлалын Монголын Сэтгүүл” №2(5), х 13-15
2. Ганзаяа.С, Энхбаатар.Л, Нямдаваа.П, Базаргүр.Д, 2006: Сүрьеэгийн өвчлөл, газарзүйн бүсийн хамаарлын асуудалд, “Халдварт Өвчин Судлалын Монголын Сэтгүүл” №2(9), х 9-10
3. ДЭМБ, 1994: “Сүрьеэгийн илрүүлэлт эмчилгээ”, Улаанбаатар 34 х;
4. ДЭМБ, 1995: “ Сүрьеэгийн хөтөлбөр, Сүрьеэтэй тэмцэх ажлын ерөнхий зохион байгуулалт”, УБ, 14х;
5. ДЭМБ, 1995: “ Сүрьеэгийн эмчилгээ, Үндэсний хөтөлбөрийн гарын авлага” , УБ, 90 х;
6. ДЭМБ, 1998: “Сүрьеэгийн эмчилгээ-Сүрьеэтэй тэмцэх хөтөлбөрийн гарын авлага”, Улаанбаатар, 90 х;
7. ДЭМБ, 1998: “ Эмэнд дасалтай сүрьеэгийн эмчилгээний гарын авлага” , УБ, 50х;
8. ДЭМБ, 1999: “Шорон дахь сүрьеэтэй тэмцэх гарын авлага” , Улаанбаатар, 98 х;
9. ДЭМБ, 2001: “ ДОТС-ын бодлогын талаарх асуулт , хариултууд”, УБ, 20 х;
10. ДЭМБ, 2001: “Шорон дахь сүрьеэтэй тэмцэх хөтөлбөрийн удирдагчдад зориулсан гарын авлага”, Улаанбаатар, 190 х;
11. Дондог.Н, Наранбат.Н, Цэрэнбалжид. Ц, Отгонцэцэг. Д, Сувдмаа. Н, Оргил. Ц, 2004: Монгол улсын хүн амын сүрьеэ өвчний эпидмиологийн зарим асуудал, ““Сүрьеэ судлалын тулгамдсан асуудлууд” онол практикийн бага хуралын илтгэлийн хураангуй ; 13-22х;
12. Наранбат.Н, 2005: “ Монгол улсад ялгасан сүрьеэгийн нянгийн эмийн дасал ба удамшлын хэв шинж”, Ангаах Ухааны докторын зэрэг горилж бичсэн тезис, Улаанбаатар;
13. Наранбат.Н, Оюундэлгэр.Д, Цогт. Г, 1999: Монгол улсын сүрьеэгийн өвчлөл ихтэй аймагуудад анхдагч дасалтай сүрьеэгийн тархалтын түвшинг судалсан дүн, “ АУИС-Эрдмийн чуулган 41”, 21 х;

-
-
14. Наранбат.Н, Отгонцэцэг.Д, Хандаасүрэн.Д, Цэрэнбалжид.Ц, 2001: Сүрьеэтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн нийгмийн эрүүл мэндийн үр дүн, “Халдварт өвчин судлалын тулгамдсан асуудлууд онол практикийн бага хурлын илтгэлийн хураангуй”, 10 х;
 15. Наранбат.Н, Батхуяг.Б, Уранчимэг.Б, Цогт.Г, 2001: Монгол дахь сүрьеэгийн өвчлөл 1990-ээд оны хандлага, “Монголын Ангаах Ухаан”, № 3(116), 134-137 х;
 16. Нямдаваа.П, 1996: “Нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд” УБ, 340 х;
 17. Пүрэвдорж. Б, 2003: Сүрьеэгийн үүсгэгчийн молекул биологийн оношлогоо, ялган дүйлт, Ангаах Ухааны машистрын зэрэг горилж бичсэн тезис, Улаанбаатар;
 18. СҮТ, 1994 : “Сүрьеэтэй тэмцэх ажлын орчин үеийн концепц, Үндэсний нэгдүгээр семинар”, УБ, 162 х;
 19. СҮТ, 1995 : “Сүрьеэ өвчний дүн бүртгэлийн мэдээ”, УБ, 32 х;
 20. СҮТ, 1995 : “Сүрьеэтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн чиглэл, Үндэсний хоёрдугаар семинар”, УБ, 106 х;
 21. СҮТ, 1998: “Сүрьеэ өвчний дүн бүртгэлийн мэдээ”, УБ, 14 х;
 22. СҮТ, 1998: “Сүрьеэтэй тэмцэх үндэсний хөтөлбөр ба төр засгийн дэмжлэг, Үндэсний гуравдугаар семинар”, УБ, 310 х;
 23. СҮТ, 1999: “Сүрьеэтэй тэмцэх ажлыг зохион байгуулахуй”, УБ, 54 х;
 24. СҮТ, 2000: “Сүрьеэгийн хяналт, Үндэсний дөрөвдүгээр семинар”, УБ, 146 х;
 25. Төмөрбаатар.Л, Наранбат.Н, 2003: “Эрүүл мэндийн сайн дурынханы гарын авлага”, УБ, 24 х;
 26. Ханс. Л. Райдер, 2002: “Сүрьеэ өвчний хяналтын тархвар судлалын үндэс”, УБ, 12, 13-106 х;
 27. ХӨСҮТ, 2001: “Сүрьеэгийн дүн бүртгэлийн мэдээ”, УБ, 32 х;
 28. ХӨСҮТ, 2002: “Сүрьеэгийн дүн бүртгэлийн мэдээ”, УБ, 36 х;
 29. ХӨСҮТ, 2003: “Сүрьеэгийн дүн бүртгэлийн мэдээ”, УБ, 36 х;
 30. ХӨСҮТ, 2002: “Тарилгатай халдварт өвчнүүдийн тандалт, сэргийлэлт, оношлогоо, шинжилгээ”, УБ, 150 х;
 31. Цэрэнбалжид.Ц, Наранбат.Н, 2004: “Сүрьеэгийн дүн бүртгэлийн мэдээ” товхимол, Улаанбаатар, 52 х;
-
-

-
-
32. Цэрэнбалжид.Ц, Наранбат.Н, 2005: “ Сүрьеэгийн дүн бүртгэлийн мэдээ” товхимол, Улаанбаатар, 11 х;
33. Цэрэнбалжид.Ц, Наранбат.Н, 2006: “ Сүрьеэгийн дүн бүртгэлийн мэдээ” товхимол, Улаанбаатар, 11 х;
34. Цэрэнбалжид.Ц, Наранбат.Н, 2004 : Монгол улсын хүн амын сүрьеэгийн өвчлөлийн хандлага, “Сүрьеэ судлалын тулгамдсан асуудлууд” онол практикийн бага хуралын илтгэлийн хураангуй ; 7-12х;
- 35.Энхбаатар.Л, Чулуун.Н, Наранбат.Н, 2004: “ Сүрьеэтэй тэмцсэн нь” , Улаанбаатар. 245х
- 36.Энхбаатар. Л, 1999: Нарны идэвхжил зарим халдварт өвчний дэгдэлтэнд нөлөөлөх нь, биоанагаах ухааны докторын [Ph.D] зэрэг горилсон бүтээл.
- 37.Энхбаатар.Л. Жамъяншарав.Б, 2004: Сүрьеэгийн зарим үзүүлэлтийн хандлага” Сүрьеэ судлалын тулгамдсан асуудал Сүрьеэгийн алба байгуулагдсаны 80 жилийн ойд зориулсан онол практикийн бага хурлын хураангуй

Орос хэлээр

38. Визель. А.А, 1999: “Туберкулёз”, Москва, с 215
- 39.Ивицкий. Г.И, 1928: Итоги первой медико-санитарной экспедиций, задача второй, “ Хозяйство Монголии”, 1: 100-110
40. Ивицкий. Г.И, 1928: Итоги второй медико-санитарной экспедиций, задача второй, “ Хозяйство Монголии”, 5: 90-99
- 41.Мандельштам. Ф, 1938: О туберкулёзе в МНР, “ Современная Монголия”, 4-6(29-31): 81-89
- 42.Петровский.Б.В (главный редактор) 1984: “Энциклопедический словарь медицинских терминов, издание первое, т.3, 276 с;
- 43.Хоменко.А.Г, 1996: “Туберкулёз”, Москва, 45 с;

Англи хэлээр

- 44.Chan.T. Y, 1999: Seasonal variations in vitamin D status and the incidence of tuberculosis in different countries, Respiration, 66, p196;
- 45.Douglas. A. S, Strachan.D.P, Maxwell. J. D, 1996: Seasonality of tuberculosis the reverse of other respiratory diseases in the UK. Thorax 51, p 944-946;

-
-
46. Davies. P.D.O, 1997: Sesonality of tuberculosis , Thorax 52, p 398;
 47. Douglas .A. S, Strachan. D.P, Maxwell.J.D, 1997: Sesonality of tuberculosis , Thorax 52, p 398;
 48. Friedman.L.N, Sullivan.G.M, Bevilaqua.R.P, Loscos.R, 1987: Tuberculosis screening in alcoholics and drug addist. Am Rev Respir Dis 136, p1188-92;
 49. Holmes.C.B, Hausler.H, Nunn.P, 1998: A review of sex differences in the epidemiology of tuberculosis. The International Journal of Tuberculosis and Lung Disease 2, p 96-104;
 50. Nagayama. N, Ohmori. M, 2006 : Seasonality in varios forms of tuberculosis, The International Journal of Tuberculosis and Lung Disease 10(10), p1117-1122
 51. Powell.D.A., 1999: Tuberculosis limpadenitis. In: Schlossberg.D, ed. Nontuberculous mycobacterial infections, Philadelphia, PA, USA: BW Saunders Co, p 186-194;
 52. Rios.M, Garcia.J.M, Sanchez.J.A, Perez.D.A. 2000: A statistical analysis of the seasonality in pulmonary tuberculosis, European J Epidemiol 16: p483-488:
 53. Vargas.M.H, Furuya.B.E.Y, Perez-Guzman.C, 2004 : Effect of altitude on the frequency of pulmonary tuberculosis, The International Journal of Tuberculosis and Lung Disease 8(11); p 1321-1323
 54. WHO, 1998: Crossroads in TB Control, Geneva, 52 pp
 55. WHO, 2000: Global Tuberculosis control report, Geneva, 185 pp;
 56. WHO, 2003: Global Tuberculosis control report, Geneva, 200 pp;
 57. WHO, 2003: Stop TB do it with DOTS, WPRO, Manila, 16 pp;